



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 1/389

Улаанбаатар хот

А.Гиймаад сахилгын  
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13, 37.1.18, 48 дугаар зүйлийн 48.1.1, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын 1.3.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.1, 10.4, 10.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Алтан-Очирын Гиймаа нь холбогдох хууль, тогтоомж, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлээгүй нь Хяналт шалгалтын газрын хяналтын улсын байцаагчийн 2024 оны 4353 дугаар дүгнэлтээр тогтоогдсон тул түүнд 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс “өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах” сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Өдөр тутмын үйл ажиллагаандаа хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргээ хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгч А.Гиймаад үүрэг болгосугай.

3.Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар (Г.Анхныбаяр)-т, Нийслэлийн Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс (П.Мөнхбаатар)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (Д.Давааням)-т тус тус даалгасугай.

4.Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА

Д.ДЭЛГЭРСАЙХАН



142402496